



МОНГОЛ АРДЫН ХУВЬСГАЛТ НАМЫН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙИ ТОГТООЛ

2004 оны 4 дугаар
сарын 10-ний өдөр

№ ...10

Улаанбаатар
хот

УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ ТУХАЙ

МАХН-ын Удирдах Зөвлөлөөс ТОГТООХ НЬ:

1. Монгол Улсын Их Хурлын 2004 оны ээлжит сонгуульд Монгол Ардын Хувьсгалт Нам /МАХН/ оролцооор шийдвэрлэсүгэй.
2. Монгол Улсын Их Хурлын 2004 оны ээлжит сонгуульд МАХН оролцох тухай Сонгуулийн Ерөнхий Хороонд бичгээр илэрхийлж зохих журмын дагуу бүртгүүлэх ажлыг зохион байгуулахыг Ерөнхий нарийн бичгийн дарга /Д.Идэвхтэн/-д даалгасугай.



Хуудбар үнэн:
Улс төрийн ажилтан

Л.Баярмагнай

БНМАУ-ын Дээл шүүхийн

Дээл Француз Улсын Ихчөлөөний

1990 оны 5-р сарын 16-ны өдрийн 1-р тогтоолоор

Монголын Улсын Ихчөлөөний

АЛИВАА НАМ УЛС ТӨРИЙН АМЬДРАЛД ОРОЛ ЦОХДОО БНМАУ-ЫН БҮРЭН ЭРХ ТУСГААР ТОГТНОЛ. ҮНДЭСНИЙ ЭВ НЭГДЛИЙГ САХИН ХАМГААЛЖ, ҮНДСЭН ХУУЛЬ БОЛОН ТӨРИЙН БУСАД ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХҮНДЭТГЭН БИЕЛҮҮЛЖ МОНГОЛ ЭХ ОРОН, АРД ТҮМНИЙ ЭРХ АШИГТ НИЙЦСЭН ҮИЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ ҮҮРЭГТАЙ.

намыг улсын бүртгэлд бүртгэж өөрийн дүрэм, мөрийн хөтөлбөрийнхөө дагуу БНМАУ-ын нутаг дэвсгэрт улс төрийн үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрөв.

ТАМГА

ДАРГА

У.Шарандорж

Гишүүн

Д.Баяасан

Г.Чирит. Г.Номын



МОНГОЛ АРДЫН ХУВЬСГАЛТ НАМЫН БАГА ХУРЛЫН ТОГТООЛ

2004 оны 5 дугаар
сарын 15-ний өдөр

№ 05

Улаанбаатар
 хот

МӨРИЙИХ ХӨТӨЛБӨРИЙГ БАТЛАХ ТУХАЙ

МАХН-ын Бага хурлаас ТОГТООХ НЬ:

МАХН-ын Удирдах Зөвлөлөөс оруулсан УИХ-ын ээлжит сонгуульд оролцох МАХН-ын Мөрийн хөтөлбөрийг сайшаан баталсугай.



Д.ИДЭВХТЭН

М.ЭИХБОЛД

МОНГОЛ АРДЫН ХУВЬСГАЛТ НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

2004 оны 5 дугаар
сарын 15-ны өдөр

Улаанбаатар
хот

ТАНЫ ТӨЛӨӨ ТАНТАЙ ХАМТ

Монгол Улсын тусгаар тогтнолыг сэргээн бататгаж, хөгжил, дэвшлийн замд оруулсан, хамгийн хариуцлагатай, бүтээлч, эрч хүчтэй улс төрийн хүчин - Монгол Ардын Хувьсгалт Нам 2004 оны Улсын Их Хурлын сонгуульд оролцох "ТАНЫ ТӨЛӨӨ ТАНТАЙ ХАМТ" сонгуулийн мөрийн хөтөлбөрөө сонгогч Танд хүргэж байна.

Монгол Ардын Хувьсгалт Нам:

- Улсын Их Хурлын 2000 оны сонгуульд оролцсон мөрийн хөтөлбөрийнхөө хэрэгжилтийн гол гол үр дүнг бататган үргэлжлүүлж,
- эх орныхоо хөгжил, дэвшил, түмэн олныхоо аз жаргалтай сайн сайхан амьдралын төлөө Монгол хүний оюуны өндөр чадавх, хөдөлмөрлөж бүтээх чадвар, боломжид тулгуурлаж,
- өргөн олон түмнийхээ шууд оролцоо, дэмжлэгтэйгээр нийгэмд бий болгож чадсан улс төрийн тогтвортой байдал, ардчиллын үнэт зүйлсийн төлөвшил, хөгжил, маргаашдаа итгэлтэй байж, бүтээж амьдрах өөдрөг сэтгэлийг урамшуулан дэмжиж,
- шилжилтийн үеийн эдийн засгийн хямрал, уналтыг эцэслэн зогсоож тогтвортой, эрчимтэй хөгжил, өсөлтийн эхлэлийг найдвартай тавьсан шинэчлэлийн бодлого, үйл ажиллагааныхаа цаашдын зорилтыг нягтлан тооцож,
- олон улсын тавцанд олж авсан өндөр нэр хүнд, Монгол Улсын ардчилсан хөгжлийг дэмжин хамтран ажилладаг олон улсын байгууллага, гадаад орнуудтай тогтоосон харилцаа, хамтын ажиллагааны үр өгөөжийг ашиглаж

ирэх 4 жилд бодитой хэрэгжүүлж чадах цогц бодлого, зорилтуудаа тодорхойлон дэвшүүлж байна.

НЭГ. НИЙГМИЙН БОДЛОГО

**АЖЛЫН БАЙР-
АМЬДРАЛЫН БАТАЛГАА**

**Хүний хөгжлийг хангах, айл бүрийн тав тухтай, чинээлэг амьдралын
орчинг бүрдүүлэхэд чиглэгдсэн нийгмийн үйлчилгээг хүртээмжтэй болгоно.**

**1. Боловсролын чанарыг дээшлүүлэх, стандартыг олон улсын
жишигт нийцүүлэх, бүтээлч сэтгэлгээтэй, бодит чадвартай мэргэжлийн**

боловсон хүчин бэлтгэхэд чиглэсэн хүртээмжтэй, чанартай үйлчилгээг үзүүлэх зорилтыг хэрэгжүүлнэ.

- Ерөнхий боловсролын сургуульд хүүхдийг 7 нааснаас эхлэн элсүүлж, 11 жилийн тогтолцоонд бүрэн шилжүүлэн сургалтын шинэ стандартыг нэвтрүүлнэ.
- Ерөнхий боловсролын сургуулийн ачааллыг багасгах талаар хэрэгжүүлж буй арга хэмжээг үргэлжлүүлж сургалтын хэвийн орчинг бүрдүүлнэ.
- Ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвүүдийг мэргэжлийн багшаар бүрэн хангана.
- Аймаг, нийслэлд зайн сургалтын төв байгуулж багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтыг тогтмолжуулна.
- Ерөнхий боловсролын сургуулиудын компьютерийн хангамжийг сайжруулан сургалтад мэдээллийн төхнологид суурилсан арга барилыг нэвтрүүлнэ.
- Гоц авьяастай хүүхдүүдийг хөгжүүлж, чадварлаг мэргэжилтэн, эрдэмтдийг бэлтгэх ажлыг ерөнхий боловсролын сургуулиас эхлэх зорилгоор байгалийн шинжлэх ухааны сургалттай тусгай сургуулийг байгуулна.
- Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын хичээлээс гадуурх сургалт, амьдрах ухааны хичээл, дадлагын баазыг өргөжүүлэн хөгжүүлнэ.
- Сургуульд хамрагдаагүй хүүхдүүдийн 50-иас доошгүй хувийг боловсрол нөхөн олгох сургалтад хамруулна.
- Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын орчин, чанарыг сайжруулан сурагчдын тоог нэмэгдүүлэх арга хэмжээ авч сургалтыг зах зээлийн эрэлттэй уялдуулан шинэ түвшинд гаргана.
- Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны зардлыг төрөөс үргэлжлүүлэн санхүүжүүлнэ.
- Эмзэг бүлгийн болон бага орлоготой өрхийн 3 ба түүнээс дээш хүүхэд нь зэрэг сурдаг өрхийн нэг хүүхдэд хичээлийн хэрэгслийг үнэ төлбөргүй олгоно.
- Нэгдүгээр ангийн сурагчдыг цайны завсарлагатай болгож зардлыг нь төрөөс хариуцна.
- Сургуулийн өмнөх насны хүүхдүүдийн цэцэрлэгт хамрагдалтыг нэмэгдүүлж, цэцэрлэгүүдийн сургалтын хэрэгсэл, тоглоом, наадгайн хангамжийг сайжруулна.
- Оюутанд төрөөс үзүүлж буй тусlamж, дэмжлэгийг үргэлжлүүлнэ.
- Гадаадад сурх оюутан, магистрант, докторантын тоог нэмэгдүүлнэ.
- Дээд боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөр хэрэгжүүлнэ. Их сургуулиудийн сургалт, эрдэм шинжилгээний ажлын чанар, үр өгөөжийг дээшлүүлнэ.

2. Иргэдийн идэвхтэй оролцоонд тулгуурласан, өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлийг эрхэм болгосон эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэн хөгжүүлнэ.

- Эх, нялхаст үзүүлэх эрүүл мэндийн тусlamжийг онцгойлон анхаарч, "Мянганы тунхаглал"-д нийцүүлэн эх нялхсын эндэгдлийг бууруулна.

- Баг, сумын болон өрхийн эмнэлгүүдийг тухайн шатны стандартыг хангасан эрүүл мэндийн төвүүд болгон хөгжүүлнэ.
- Баг, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийг лабораторийн шинжилгээний хурдавчилсан оношлуураар тасралтгүй хангах тогтолцоог бүрдүүлнэ.
- Бүх сумын эрүүл мэндийн төвүүдийг эхо (хэт авиан дүрслэлийн)-оношлогооны аппаратаар тоноглож, эмч, мэргэжилтнүүдийг нь дүрслэл оношлолын аргад сургана.
- Сумын эрүүл мэндийн төвүүдийг компьютерээр хангаж, эрүүл мэндийн мэдээллийн сүлжээ, төле-анагаахын үйлчилгээнд холбох ажлыг эхлүүлнэ.
- Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд үйлчлүүлж буй нийгмийн эмзэг бүлгийнхний зардлыг төр хариуцна.
- Дархлаажуулалтад хавсарсан вакцин нэвтрүүлэх замаар эрүүл хүүхдэд хийх тарилгын тоог цөөрүүлнэ.
- Бүсийн оношлогоо-эмчилгээний төвүүд, аймаг, хот, сум дундын эмнэлгүүдийн материаллаг бааз, боловсон хүчний мэдлэг, чадварыг дээшлүүлэх арга хэмжээг дэс дараатай авч хэрэгжүүлнэ.
- Гадаадын хөрөнгө оруулалт, мэргэжлийн туслалцааг татах замаар Улаанбаатар хотод орчин үеийн дээд түвшний оношлогоо-эмчилгээний төвийг байгуулж, эрүүл мэндийн тусламж авахаар гадаадад эмчлүүлдэг чирэгдлийг багасгана.
- Мэдээллийн технологийг эрүүл мэндийн салбарт эрчимтэй нэвтрүүлж, эрүүл мэндийн мэдээллийн цаасгүй технологи, төле-анагаахын сүлжээ байгуулан гадаадын лавлагааны төвүүдтэй холбох ажлыг эхлүүлнэ.
- Анагаах ухааны боловсрол олгох тогтолцоог боловсронгуй болгож, эмч нарын ур чадварыг нэмэгдүүлэн хариуцлагын тогтолцоог сайжруулна.
- Эрүүл мэндийн даатгалын тогтолцоог боловсронгуй болгон бэхжүүлнэ.
- Үндэсний бөх, морь, сурын спортыг уламжлал, шинэчлэлийг хослох үндсэн дээр хөгжүүлнэ.
- Хүн амд эрүүл аж төрөх ёсыг нэвтрүүлэх, нийтийн биөийн тамирыг хөгжүүлэх ажлыг бүх талаар дэмжинэ. Бүсүүдэд спортын цогцолбор барина.
- Спортын олон төрлийн тэмцээн, дасгалжуулалтыг олон улсын түвшинд явуулах, хүн амыг чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх бололцоог хангасан "Олимпийн цогцолбор"-ыг Улаанбаатар хотод байгуулна.
- Их спортыг дэмжиж олимп, дэлхий, тивийн хэмжээнд амжилт гаргах найдвартай спортын төрлүүдийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр сонгож дэмжин хөгжүүлнэ.

3. Ажлын байр нэмэгдүүлэх, ажилгүйдлийг бууруулах бодлогыг тууштай хэрэгжүүлнэ.

- Ядуурлыг бууруулах, иргэдийн орлогыг тогтвортой болгох, өсгөх зорилгоор ажлын байрыг нэмэгдүүлэх цогц арга хэмжээ авч 145 000 ажлын байр шинээр бий болгоно.
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээний арга хэлбэрийг боловсронгуй болгох, зарцуулах хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх, үр ашгийг дээшлүүлэх замаар үйлчилгээний хүрээг өргөжүүлэх арга хэмжээ авна.

- Хөдөлмөрчид эрхээ хамгаалулахад дэмжлэг үзүүлж, хөдөлмөрийнхөө үр шимийг шударга хүртэх боломжийг нэмэгдүүлнэ. Үйлдвэрчний эвлэлийн болон эздийн байгууллагуудтай хамтран нийгмийн түншлэлийн харилцааг хөгжүүлнэ.
- Хоршоо, нөхөрлөл байгуулах, аж ахуй эрхлэх ур чадварын сургалт болон зээл, санхүүгийн эх үүсвэрээр дэмжих замаар иргэдэд ажлын байраа тогтвортой хадгалах, орлогоо нэмэгдүүлэхэд нь тусална. Жижиг зээлийн үйлчилгээний хүрээг өргөтгөж, үйлдвэрийн тоног төхөөрөмж, үржлийн мал зэрэг үйлдвэрлэлийн нэн хэрэгцээт зүйлийг зээл, түрээс, лизингээр эзэмшигжүүлэх хэлбэрийг өргөн ашиглана.
- Гадаадын өндөр хөгжилтэй орнуудад хөдөлмөр эрхлэгчдийн тоог нэмэгдүүлэх, тэдний эрх, ашиг сонирхлыг хамгаалах талаар идэвхтэй үйл ажиллагаа явуулна.
- Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, төрийн албан хаагчдын болон төсөвт байгууллагад ажиллагсдын үндсэн цалинг инфляцийн түвшинтэй уялдуулан индексжүүлнэ. Ингэхдээ инфляцийн түвшингээс 1:1.5 харьцаатайгаар түрүүлж өсгөнө. Төсвийн санхүүжилтийн шинэ зарчимд нийцүүлэн төрийн албанад ажиллагсадад ажлын үр дүнгээр шагнал, урамшил олгох журмыг бүрэн хэвшүүлнэ.
- Тахир дутуу болон тэтгэвэр тогтоолгохын өмнөх насын хүмүүсийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар тусгайлсан хөтөлбөрүүдийг гадаад, дотоодын хандивлагчдын дэмжлэг, тусламжтайгаар хэрэгжүүлнэ.
- Бага орлоготой айл өрхийн аж ахуй эрхлэлтийг тэдний гэр бүлд үзүүлэх нийгмийн тэтгэмж, тусламж, хөнгөлөлттэй хослуулан зохистой хэлбэрээр дэмжинэ.
- Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн хэмжээг амьжиргааны түвшингийн өөрчлөлт, инфляцийн түвшинтэй уялдуулан жил бүр индексжүүлэх зарчимд шилжинэ. Ингэхдээ инфляцийн түвшингээс 1:1.5-ын харьцаатайгаар түрүүлж өсгөнө.
- 1995 оноос өмнө ба хойно тогтоосон тэтгэврийн зөрүүг ойртуулж, тэтгэврийн тогтолцоог боловсронгуй болгоно.
- Улсын тэтгэврийн даатгалын тогтолцоог боловсронгуй болгож хөгжүүлэхийн зэрэгцээ хувийн хэвшлийн оролцоотой тэтгэврийн сайн дурын даатгалын тогтолцоог бий болгоно.
- Таваас доош жил шимтгэл төлсөн даатгуулагчид олгох ажилгүйдлийн даатгалын тэтгэмжийг авч байсан цалин хөлсний 50 хувьд хүргэж нэмэгдүүлнэ.
- Хөдөлмөрийн нөхцлийг сайжруулах, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин болон ажилгүйдлээс урьдчилан сэргийлэх үйлчилгээний шинэ хэлбэрийг ажил олгогч, ажилтны эрх ашигт нийцүүлэн нэвтрүүлж зардлыг нийгмийн даатгалын сангаас санхүүжүүлнэ.

4. Нийгмийн эмзэг хэсэгт зориулан төрөөс олгож байгаа хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх, орлого багатай өрхийн амьжиргааг дэмжиж хөгжүүлэх зарчмыг тууштай хэрэгжүүлнэ.

- Сум, хороонд нийгмийн халамж, асрамж, үйлчилгээг нийгэм, хамт олонд түшиглэсэн зарчмаар хүргэх нэг цэгийн үйлчилгээг нэвтрүүлж эхэлнэ.
- Шинэ гэр бүлийг төрөөс дэмжих бодлогыг хэрэгжүүлнэ. Анх удаа гэрлэж буй шинэ гэр бүлд нэг удаа 500000 төгрөгийн буцалтгүй тусламж олгоно.
- Өмч хувьчлалаас олсон орлогын 3 хувийг тусгай санд төвлөрүүлэн ахмад настны нийгмийн хамгааллыг дээшлүүлэх арга хэмжээнд зарцуулна.
- Ашиглалтад орж байгаа орон сууцнаас 2 хувийг ахмад настан, тахир дутуу иргэдэд хуваарилах журмыг нэвтрүүлнэ.
- Асрамжийн газрын үйлчилгээнд төрийн бус байгууллага, хувийн хэвшил, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.
- Хүн амын өсөлтийг төр, засгаас дэмжиж шинээр мэндэлсэн хүүхэд бүрт нэг удаа 100000 төгрөгийг тэднийг өсгөж бойжуулахад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор олгоно.
- Хүн амын өсөлтийг урамшуулж, 3 ба түүнээс дээш хүүхэдтэй өрхийг олон хүүхэдтэйд тооцон өргөтгөж 1 өрхөд жилд 100 000 төгрөгийн буцалтгүй тусламж олгоно.
- Залуучууд, залуу гэр бүлд зориулсан орон сууцны урт хугацааны зээлийн сангийн үйл ажиллагааг өргөтгөж, үүнд гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна.
- Төрийн албан хаагчид, ялангуяа багш, эмч болон цэрэг, цагдаа, шүүх, прокурорын байгууллагад ажиллагчдыг хямд төсөр орон сууц, хөдлөх болон үл хөдлөх хөрөнгөтэй болоход нь зориулсан урт хугацааны зээл олгох эрх зүйн орчинг бүрдүүлж хэрэгжүүлнэ. Цаашид нийт иргэдэд орон сууцтай болоход нь зориулж урт хугацааны зээл олгох системийг нэвтрүүлнэ.

5. Соёл, урлагийн салбарын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгож, бие даан хөгжих боломжийг дээшлүүлж төрийн дэмжлэг, зохицуулалтыг оновчтой болгоно.

- Хөдөөгийн соёл, урлагийн байгууллагуудын барилгыг шинэчлэх, засварлах болон эдгээр байгууллагыг хөгжим, техник хэрэгслээр хангахад зориулах хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлж, үйлчилгээний хүрээг өргөтгөж чанаржуулна.
- Соёлын өвийг хадгалж хамгаалах, сурталчлах, ашиглах асуудлыг зах зээлийн харилцаанд нийцүүлэн хөгжүүлнэ.
- Уламжлалт шашин болон монгол бичгээ судлах, зүй зохистойгоор өвлөх ажлыг өргөжүүлэн гүнзгийрүүлнэ.
- Сонгодог болон ардын урлаг, хүүхдэд зориулсан урлагийг төрөөс дэмжин хөгжүүлнэ.
- Урлаг, соёлын үндэсний цогцолбор барих ажлыг эхлүүлнэ.
- Музейн үйл ажиллагааг шинэчлэн, сургалт-эрдэм шинжилгээний чиглэлтэй болгоно.
- Номын сангийн үйлчилгээг өргөтгөж, хүн амд мэдээлэл хүргэх төв болгон ажиллуулна.

- Олон нийтийн мэдээллийн болон хувийн радио, телевизийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг бүрдүүлнэ.

6. Үндэсний шинжлэх ухааны чадавхийг бэхжүүлэн бүтэц, менежментийг нь боловсронгуй болгож, шинжлэх ухаан, технолөгийн салбарыг эрчимтэй хөгжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

- Монгол Улсын шинжлэх ухаан, технологийн үндэсний чадамжийг улс орны эдийн засаг, нийгмийн тогтвортой өсөлтийн тулгуур хүчин зүйл болгон хөгжүүлэх "Мастөр төлөвлөгөө"-г боловсруулан хэрэгжүүлнэ.
- Улс орны хөгжлийн тэргүүлэх чиглэлд шийдвэрлэх нөлөө бүхий үндсэн салбаруудаар технологийн инкубатор, технологи дамжуулах төвүүдийн зохистой бүтэц, мөханизмыг бий болгон хөгжүүлнэ.
- Шинэ технологи нэвтрүүлэхэд зориулсан хувийн хэвшлийн санхүүгийн дэмжлэг, хөрөнгө оруулалтыг татварын бодлогоор хөхиулэн дэмжинэ.
- Шинжлэх ухааны байгууллагуудын чадавхийг бэхжүүлэн, суурь судалгааны өгөөж, үр нөлөөг дээшлүүлж, тэдгээрийг улс орныхоо хөгжлийн чухал хүчин зүйл болгон хөгжүүлнэ.
- Дотооддоо болон гадаадын өндөр хөгжилтэй орнуудад эрдэм шинжилгээний боловсон хүчин, залуу эрдэмтдийг бэлтгэх үйл ажиллагааг дэмжих хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.
- Хөгжилтэй орнуудад бэлтгэгдсэн нарийн мэргэжлийн боловсон хүчний эрдэм шинжилгээний чадавхийг ашиглах техник, технологийн бааз нөхцөлийг шинжлэх ухааны байгууллага, их сургуулиудад бий болгохыг зорино.
- Шинжлэх ухаан, технологийн салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг татах, дэлхийн шилдэг менежментийн ололтыг нэвтрүүлэх зохистой орчин бүрдүүлнэ.
- Орчин үеийн шинжлэх ухаан, технологийн ирээдүйтэй чиглэлүүдээр судалгааны зорилтот хөтөлбөрүүд боловсруулан хэрэгжүүлнэ.
- Улс орны хөгжилд бодитой нөлөө үзүүлж чадах судалгаа, шинжилгээний чиглэлүүдийг нарийвчлан тогтоож санхүүжүүлэх чиглэл баримтлана. Эдгээр чиглэлээр эрдэм шинжилгээний ажлын бааз, лабораторийн чадавхийг нэмэгдүүлнэ.
- Шинжлэх ухаан, технологийн мэдээллийн төрөлжсөн сан, сүлжээг өргөтгөн хөгжүүлж, мэдээллийн чанар, агуулга, багтаамжийг сайжруулна.
- Шинжлэх ухааны бүтээл, технологийн шинэ шийдлийн оюуны өмчийн хамгаалалтыг сайжруулж, оюуны хөдөлмөр, оюуны өмчийн нийгмийн болон эдийн засгийн суурь үнэлгээг дээшлүүлэх зохистой тогтолцоог бий болгон хөгжүүлнэ.

ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

**ЭРЧИМТЭЙ ХӨГЖИЛ-
ИТГЭЛТЭЙ ИРЭЭДҮЙ**

Хувийн хэвшилд тулгуурласан бүтцийн өөрчлөлтийг гүнзгийрүүлэн эх орны үйлдвэрийн бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх,

экспортын бүтээгдэхүүний бүтцийг сайжруулах үндсэн дээр эдийн засгийн тогтвортой өндөр өсөлтийг хангана.

1. Эдийн засгийн хөгжлийг эрчимжүүлэн өндөр өсөлтийг хангаж дотоодын нийт бүтээгдэхүүний жилийн дундаж өсөлтийг 7-гоос доошгүй хувьд хүргэнэ.

- Гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, дотоодын хөрөнгө оруулагчдыг урамшуулах таатай орчинг бий болгоно.
- Монгол Улсын зээлийн ангиллыг ахиулж, Засгийн газрын үнэт цаас /бонд/-ыг олон улсын санхүүгийн зах зээлд арилжаалах үйл ажиллагааг эхлүүлнэ.
- Олон улсын бирж дээр хувьцаа гарган арилжих замаар уул уурхайн салбарт хөрөнгө оруулалтыг дэмжих бодлого хэрэгжүүлнэ.
- Жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах эрх зүйн орчинг бий болгож, бизнес эрхлэгчид болон банк, санхүүгийн байгууллага, иргэдийг хөрөнгийн зах зээлд чөлөөтэй оролцох нөхцөлийг бүрдүүлж, хөрөнгийн зах зээлийн үйл ажиллагааг сэргээж идэвхжүүлнэ.
- Мөнгө-санхүүгийн таатай орчинг бүрдүүлж хуримтлалыг нэмэгдүүлж, түүгээр дамжуулан ажлын байрыг нэмэгдүүлэх арга хэмжээ авна.
- Зээлийн хүүг бууруулах шат дараалсан арга хэмжээг мөнгө, төсөв, татварын бодлогоор дамжуулан хэрэгжүүлнэ.
- Үнэ цэнэ бүхий томоохон аж ахуйн нэгжүүдийн хувьчлалыг үргэлжлүүлнэ. Ингэхдээ тэдний чиглэл, зориулалтыг өөрчлөхгүй байх зарчмыг баримтална.
- Эрдэс баялгийн нөөцийг өсгөнө. Хувийн хөрөнгөөр хайгуул, судалгаа хийхийг дэмжинэ.
- Хувийн хэвшлийн хөгжилд саад, бэрхшээл учруулж буй олон шат дамжлагыг цөөлөх, хүнд суртал, тусгай зөвшөөрлийн зэрэг чирэгдлийг арилгах замаар бизнес чөлөөтэй хөгжих орчинг улам таатай болгоно.
- Хувийн хэвшлийнхэн болон жижиг, дунд бизнес эрхлэгчдийн саналыг төр, засгийн шийдвэр гарахад харгалзан үздэг хамтын ажиллагааны үр ашигтай хэлбэрүүрийг дэмжин хөгжүүлнэ.
- Иргэнд гэр бүлийнх нь хэрэгцээнд газрыг нэг удаа үнэгүй өмчлүүлэх ажлыг эрчимтэй үргэлжлүүлэн, өмчилсөн газраа эдийн засаг, зах зээлийн харилцаанд оруулах эрх зүйн болон санхүүгийн таатай орчин бүрдүүлнэ.
- Жижиг, дунд үйлдвэр байгуулахад тоног төхөөрөмжийг нь урт хугацааны эээл, лизингээр нийлүүлэх арга хэмжээ авна.
- Хөдөө орон нутаг, бүс нутагт хэрэгжүүлэх төслийг зээл, татварын бодлогоор дэмжинэ.
- “Орон нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэл”-ийн хүрээнд бүс нутгийн хөгжилд нөлөө бүхий зарим үйлдвэрийг дэмжинэ.
- Засгийн газрын захиалгыг аль болох дотоодын үйлдвэрлэлээр хангах бодлого баримтлан, үйлдвэр, аж ахуйн нэгжүүдэд зах зээлээ нэмэгдүүлэхэд нь дэмжлэг үзүүлнэ.
- Үйлдвэрлэл-технологийн паркуудыг байгуулж эхэлнэ.
- Үндэсний үйлдвэрийн бүтээгдэхүүнийг давуу эдэлж хэрэглэх хөдөлгөөн өрнүүлнэ.

2. Эдийн засгийн гөл салбаруудын өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.

- Мэдээллийн технологи зэрэг мэдлэг, оюуны багтаамж ихтэй бүтээгдэхүүн, үйлчилгээний экспортыг хөхиулэн дэмжинэ.
- Уул уурхайн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний гаргалтыг нэмэгдүүлэн боловсруулалтын түвшинг дээшлүүлнэ.
- Уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг 2 дахин нэмэгдүүлнэ.
- Алт олборлолт, цэвэр зэс үйлдвэрлэлийг дорвитой нэмэгдүүлнэ.
- Оюу толгой, Таван толгой, Төмөртэйн Овоо, Цав, Асгатын орд газрыг түшиглэн уул уурхайн үйлдвэрлэлийн шинэ хүчин чадлыг бий болгож зэс, нүүрс, цайр, мөнгө, цагаан ба хар тугалга зэрэг дэлхийн зах зээлд эрэлт хэрэгцээтэй, өндөр үнэтэй ашигт малтмалыг олборлох, экспортлох үйл ажиллагааг дэмжинэ.
- Төмөртэйн орд газарт олборлох үйлдвэр байгуулан Дарханы төмөрлөгийн үйлдвэрийн түүхий эдийн хангамжийг шийдвэрлэж төмрийн экспортыг нэмэгдүүлнэ.
- Газрын тосны салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж олборлолтыг жил тутам өсгөнө. Газрын тос боловсруулах хүчин чадлыг шинээр бий болгоно. Шингэрүүлсэн хийг тээвэр, ахуйн зориулалтаар ашиглана.
- Усалгаатай тариаланг хөгжүүлэх, хөрс хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлж гурил, төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлийг тогтвортой өсгөн 2008 он гэхэд хүнсний хэрэгцээт гурилын дотоодын үйлдвэрлэлийг одоогийнхоос 2 дахин нэмэгдүүлж, хүнсний ногооны 70-аас доошгүй хувийг, төмсний хэрэгцээг 100 хувь дотоодын үйлдвэрлэлээр хангана.
- Тариаланчдад газрыг өмчлүүлэх, удаан хугацаагаар эзэмшүүлэх, машин техник, тоног төхөөрөмжийг урт хугацаагаар бага хүйтэй зээл /лизинг/-ээр олгох зэргээр газар тариалангийн үйлдвэрлэлийг дэмжинэ.
- Аялал жуулчлалын гол бүс нутаг болох Хархорин, Хөвсгөл, Өмнөговь, Хэнтий, Ховд зэрэг газарт аялал жуулчлалын цогцолбор байгуулах, үйлдвэрлэл, үйлчилгээ, дэд бүтцийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- Жилийн дөрвөн улиралд тасралтгүй үйл ажиллагаа явуулдаг аялал жуулчлалыг дэмжин хөгжүүлнэ.
- Худалдааны нэн тааламжтай хөнгөлөлт эдлэх нөхцөлийг худалдааны түнш зарим оронд тавьж шийдвэрлүүлэн гадаад зах зээлийн хүрээг тэлэх арга хэмжээ авна. Далайд гарцгүй орны хувьд дамжин өнгөрөх ачааны тээврийн тарифийн хөнгөлөлт эдлэх талаар хөрш орнуудтай гэрээ, хэлэлцээр хийнэ.
- Алтанбулаг, Замын Үүд, Цагааннуур зэрэг худалдаа, эдийн засгийн чөлөөт бүсийн үйл ажиллагааг эхлүүлж тогтвортжуулна.

3. Төсөв, санхүүгийн чадавхийг бэхжүүлнэ.

- Үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжсэн татварын бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.
- Төсвийн зарцуулалтын үр ашгийг улам дээшлүүлж, алдагдлыг бууруулна.

- Төсвийн ил тод байдлыг хангаж, санхүүжилтийг цаг хугацаанд нь саадгүй гүйцэтгэх ажлыг бататгана.
- Банкны системийн тогтвортой байдлыг хангаж эдийн засаг, нийгмийн хөгжлийг мөнгөний бодлогоор дэмжинэ.

4. Татварын иж бүрэн шинэчлэл хийж үйлдвэрлэл, хөрөнгө оруулалт, шинээр ажлын байр бий болгохыг татварын бодлогоор дэмжинэ.

- Дотоодын түүхий эдийг боловсруулж эцсийн бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэн экспортлох, ажил эрхлэлтийг дээшлүүлэн жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх, оюуны багтаамж ихтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэж экспортлоход татварын бодлогоор дэмжинэ.
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хувь хэмжээг бууруулж, ачааллыг багасгана.
- Хүн амын орлогын албан татварын шатлалыг цөөрүүлж хувь хэмжээг нь багасгана.
- Нэмэгдсэн өргтийн албан татварын хувь хэмжээг бууруулах бодлого баримтлана.
- Малчин өрх, мал бүхий иргэдээс авч буй бэлчээр ашиглалтын болон хүн амын орлогын албан татварын ялгаа, давхардлыг арилган татвар ногдуулах итгэлцүүрийг шинэчлэн тогтооно.
- Дотоодын үйлдвэрлэлийг дэмжих, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, ажлын байр шинээр бий болгоход чиглэсэн татварын зохистой бодлого явуулна.
- Татвар хураалтыг сайжруулж, татвар төлөгчдийн нэг цэгийн үйлчилгээг өргөжүүлж, томоохон татвар төлөгчдөд электрон тайлангийн систем нэвтрүүлнэ.

ГУРАВ. ДЭД БҮТЭЦ, ХӨДӨӨГИЙН БОДЛОГО

**БҮСЧЛЭЛИЙН БОДЛОГО-
ХӨДӨӨГИЙН ХӨГЖИЛ**

1. Бүсчилсэн хөгжлийн бодлогын хэрэгжилтийг гүнзгийрүүлэн, бүс нутгуудын эдийн засгийн өсөлтийг түргэтгэж, хот, хөдөөгийн хүн амын нийгэм, соёлын харилцан уялдсан цогцолбор хөгжлийг хангах нөхцлийг бүрдүүлнэ.

- Үндэсний хөгжлийн стратегийг боловсруулж бүс бүрийн онцлогт тохирсон хөгжлийн хөтөлбөр, төслүүдийг батлан хэрэгжүүлж эхэлнэ.
- Бүсийн тулгуур төвүүдийг хөгжүүлэх, тэдгээрийн дэд бүтцийг сайжруулахад чиглэсэн хөрөнгө оруулалтыг хөхиулэн дэмжинэ.
- Говийн аймгуудыг хөгжүүлэх цогцолбор бодлогыг боловсруулж хэрэгжүүлнэ.
- Бүс нутгийн хөгжил, хот байгуулалт, газар зохион байгуулалтын ажлын уялдааг хангаж газрыг өмчилж, эзэмшиж, ашигласны үр өгөөжийг хот,

хөдөөгийн хүн амын амьжиргааг жигд дээшлүүлэх тогтвортой эх үүсвэр болгох нөхцлийг бүрдүүлнэ.

- Аймаг, сумдын хүн амын хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын асуудлыг бүс дотроо уялдаатай шийдвэрлэх удирдлага, санхүүжилтийн нөхцлийг бүрдүүлнэ.
- Хөдөөд ажлын байр нэмэгдүүлж ажилгүйдэл, ядуурлыг бууруулна.
- Хадлан, бэлчээрийн талбайг нөхөн сэргээх, сайжруулах, таримал бэлчээр, хадлан бий болгох чиглэлээр хот айл, малчдын бүлэгт дэмжлэг үзүүлнэ.
- Цас, борооны ус хуримтлуулан усан сан, цөөрөм байгуулах цэгүүдийг тогтоож, хадлангийн газрыг энгийн аргаар услахад төрөөс дэмжлэг үзүүлнэ.
- Нутгийн шилмэл малын удмын санг хамгаалан ашиг шимт чанарыг нь дээшлүүлэхэд тусална.
- Мал сүргийг байгалийн гэнэтийн гамшиг хамгаалах цогц бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.
- Бүсийн тулгуур төв, томоохон хот, суурин газрын ойролцоо байгуулсан мах, сүүний чиглэлийн төрөлжсөн мал, гахай, шувуу үржүүлэх суурьшмал өрх /фермер/-ийн аж ахуйд урт хугацаагаар газар эзэмшүүлэх, ашиглаулах чиглэлээр эрх зүйн орчинг сайжруулж, дэмжлэг үзүүлэх замаар эрчимжсэн суурьшмал аж ахуйн тоог нэмэгдүүлнэ.
- Малын халдварт болон паразиттах өвчнийг оношлох, эмчлэх, түүнтэй тэмцэх арга хэмжээний чанарыг сайжруулан халдварт өвчний гаралтыг бууруулна.
- Улсын төсвийн хөрөнгө болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр 3500-аас доошгүй худагт засвар, шинэчлэлт хийж, 2800-аас доошгүй инженерийн хийцтэй худаг шинээр гаргах ажлыг говь, тал хээрийн бүсийн аймгуудад төвлөрүүлэн зохион байгуулж, иргэдийн оролцоотойгоор 1500-гаас доошгүй гар худаг гаргах арга хэмжээ авна.
- Мах, махан бүтээгдэхүүний боловсруулалтыг гүнзгийрүүлэн чанарыг олон улсын стандартын түвшинд хүргэж, экспортын зах зээлийг өргөтгөх нөхцлийг бүрдүүлнэ.
- Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, боловсруулалтыг өргөтгөх чиглэлээр тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа иргэд, аж ахуйн нэгжүүдийг дэмжинэ.

2. Эдийн засгийн өсөлтийг түргэтгэхэд дэд бүтцийн хөгжлийг чиглүүлнэ.

2.1. Эрчим хүчний хангамжийг нэмэгдүүлнэ.

- Төвлөрсөн цахилгаан хангамжийн эх үүсвэрт 40-өөс доошгүй сумын төвийг холбож, хөдөөгийн сумдын цахилгаан хангамжийг сайжруулна.
- Ойрын ирээдүйд төвлөрсөн эрчим хүчний системд холбогдох эдийн засгийн болон техникийн боломжгүй 10-аас доошгүй сум, суурин газрыг сэргээгдэх эрчим хүчээр хангах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.
- Хөдөөгийн малчин айл өрхийг нар, салхины цахилгаан эх үүсгүүрээр хангах “Буман нарны гэрэл” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж дуусгана.

2.2. Мэдээлэл, холбооны суурь сүлжээний багтаамж, ашиглалт, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлж, өрсөлдөөн бий болгон үнэ, тарифийг хямдруулах арга хэмжээ авч үйлчилгээний чанарыг дээшлүүлнэ.

- Мэдээлэл, холбооны өндөр хурдны сүлжээ бий болгоно.
- Хөдөлгөөнт холбоо хэрэглэгчдийн тоог, түүний дотор хэрэглэгч малчдын тоог нэмэгдүүлнэ.
- Томоохон бүлэг суурингийн төвүүдийн автомат төлөфон станцыг тоон технологид үе шаттай шилжүүлнэ.
- Сум, суурин газруудын холбооны салбаруудыг нарны зайн эх үүсвэрээр хангах ажлыг нэмэгдүүлнэ.
- Томоохон суурин газруудыг холбоожуулах, интэрнэтийн үйлчилгээг өргөтгэн шинэчлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- Электрон засаглалын өрөнхий үзэл баримтлал, “Электрон засаг” байгуулах хөтөлбөрийг боловсруулж, эхний үе шатыг хэрэгжүүлж эхэлнэ.
- Хөдөө орон нутагт төлөвизийн ергөн нэвтрүүлгийн дамжуулах сүлжээг тоон технологид шилжүүлэн олон сувгийн төлөвизийн программыг орон даяар хүлээн авах арга хэмжээг хэрэгжүүлж, нэвтрүүлгийн тоо болон цагийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ улс орон даяар хэт богино /FM/ долгионы олон сувгийн радио өргөн нэвтрүүлгийг хүлээн авч сонсох боломжийг бүрдүүлнэ.

2.3. “Мянганы зам” төслийг хэрэгжүүлэх ажлыг үргэлжүүлэн хэвтээ болон босоо тэнхлэгийн замыг ээлж дараатай барих замаар улсын чанартай авто замын сүлжээг өргөжүүлэх, авто замын засвар, арчлалтын ажлын хэмжээг нэмэгдүүлж чанарыг сайжруулах арга хэмжээг авна.

2.4. Төмөр замын тээврийн сүлжээг өргөжүүлэн тээх, нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх, олон улсын тээвэрт төмөр замын өрсөлдөх чадавхийг дээшлүүлнэ. Хос томөр замтай болгох, төмөр замыг цахилгаанжуулах ажлын судалгаа хийнэ.

2.5. Агаарын тээврийн үйлчилгээг өргөжүүлж түүнд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлнэ.

- Орон нутгийн нислэгийн зориулалт бүхий онгоцны парк шинэчлэхэд гадаадын хөрөнгө оруулалт болон хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлнэ.
- Монгол Улсын нутаг дэвсгэр дээгүүр дамжин өнгөрч буй нислэгийн тоог нэмэгдүүлэх нөхцлийг бүрдүүлж үйлчилгээг сайжруулна.

2.6. Хот, суурин газрыг барилгажуулах, тохижуулах эрх зүйн орчинг боловсронгуй болгож барилгад шинэ техник, технологи, орчин үеийн материал нэвтрүүлэх арга хэмжээг авна.

- Бүсийн тулгуур төвүүдийн барилгажилтын өрөнхий төлөвлөгөөг боловсруулж дуусган хэрэгжүүлж эхлэнэ.
- Орон сууц барьж байгуулах ажлыг урт хугацааны зээл, татварын бодлогоор дэмжиж, бүсийн тулгуур төвүүдэд инжөнөрийн хангамж бүхий орон сууц барих ажлыг нэмэгдүүлж амины орон сууцны хороолол барих, инжөнөрийн төвлөрсөн шугам сүлжээ, авто зам зэрэг бүтцийг бий болгоход дэмжлэг үзүүлнэ.
- 17 аймгийн 102 сумын төвийн ундны усыг цэнгэгжүүлэх тоног төхөөрөмж суурилуулан хот, суурин газрын хүн амыг стандартын шаардлагад нийцсэн ундны усаар хангана.

3. Бүс нутагт дэд бүтцийг хөгжүүлэх томоохон төслүүдийг хэрэгжүүлнэ:

Баруун бүсэд:

- Тайшир, Дөргөний усан цахилгаан станцуудыг барьж, Алтай-Тайшир-Улиастай, Дөргөн-Мянгадын 110 киловольтын өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах шугамуудыг байгуулан баруун бүсийн эрчим хүчний системийн хэрэглээг дотоодын эх үүсвэрээс хангах нөхцлийг бүрдүүлнэ.
- Баян-Өлгийн Булган, Ховдын Мөст, Увс аймгийн Баруунтуруун сумдад жижиг оврын усан цахилгаан станц барих ажлыг эхлүүлж, Завханы Тосонцэнгэл сумын усан цахилгаан станцыг барьж дуусгана.
- Өлгий, Улаангом, Ховд зэрэг хотуудын төвлөрсөн халаалтын зуух, дулааны шугам сүлжээг үе шаттайгаар шинэчлэнэ.
- Ховд-Улаангом-Хандгайт, Булган-Ярантын чиглэлийн хатуу хучилттай авто замуудыг барьж, олон улсын авто тээвэрлэлт гүйцэтгэх боломжийг бүрдүүлж Ховдын Булган - Ховд чиглэлийн авто замыг үргэлжлүүлэн барина.
- “Мянганы зам”-ын дагуух гүүрүүдийг барьж ашиглалтад оруулна.
- Мэдээлэл, холбооны Улаангом-Улиастай-Мөрөн чиглэлийн тоон сүлжээг байгуулна.

Хангайн бүсэд:

- Булган-Мөрөн, Арвайхээр-Баянхонгорын 110 киловольтын өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах шугамуудыг барьж тухайн орон нутгийн хэрэглэгчдийн цахилгаан эрчим хүчний хангамжийг сайжруулна
- Хөвсгөлийн Эрдэнэбулган сумын усан цахилгаан станцыг барьж дуусгана.
- Эрдэнэт-Булган-Мөрөнгийн хатуу хучилттай авто замыг үргэлжлүүлж, аялал жуулчлалын бүсүүдийн авто замыг сайжруулах арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
- Булганы Дашинчилэн, Завханы Яруу сумын чиглэлийн хатуу хучилттай авто замыг үргэлжлүүлэн барина.
- Архангай аймагт Орхоны гүүрийг барьж ашиглалтанд оруулна.
- Арвайхээр – Баянхонгор - Говь-Алтай - Ховдын чиглэлийн хайрган замыг хэсэгчилэн сайжруулах ажлыг үргэлжлүүлнэ.

- Сэлэнгэ мөрөнд гүүр тавих ажлыг эхлүүлнэ.
- Баянхонгор аймгийн усан хангамжийн системийг өргөтгөж шинэчилнэ.
- Булган, Цэцэрлэг, Мөрөн хотын дулааны болон усан хангамжийн системийг шинэчилнэ.

Төвийн бүсэд:

- Төвийн эрчим хүчний найдвартай ажиллагааг баталгаажуулах үүднээс Орхон, эсвэл Эгийн гол дээр 100 мвт-аас доошгүй хүчин чадалтай усан цахилгаан станц барих хөрөнгө оруулалтын асуудлыг шийдэж, барих ажлыг эхлүүлнэ.
- Улаанбаатар-Дашичилэн-Булган, Дашичилэн-Арвайхээр чиглэлийн дамжуулах сүлжээг шилэн кабелиар шинэчилж Налайх-Багануурын дамжуулах сүлжээг өргөтгөнө.
- Улаан Овоогийн нүүрсний орд газрыг түшиглэн сайн чанарын нүүрс олборлох уурхайг барьж байгуулах арга хэмжээ авна.
- Чойр-Сайншанд-Замын Үүдийн хатуу хучилттай авто замыг барина.
- Алтанбулаг-Улаанбаатар-Замын Үүд чиглэлийн олон улсын авто замын дагуу тээвэрлэгч, зорчигчдод үйлчлэх дэд бүтцийг бий болгож улс хоорондын тээвэрлэлтийг өргөжүүлнэ.
- Ерөө зөрлөгөөс Төмөртэйн төмрийн хүдрийн орд газар хүртэл 100 км төмөр замыг барьж, Өмнөговь аймгийн нутаг дахь Оюутолгой, Таван толгой зэрэг ашигт малтмалын орд газрыг эзэмшихтэй уялдуулан төмөр замын шугам барих асуудлыг судална.
- Даланзадгад хотын нисэх буудлыг ашиглалтад оруулж онгоц хөөрч, буух зурvasыг хатуу хучилттай болгоно.
- Сэлэнгэ, Говьсүмбэр, Замын-Үүд, Алтанбулаг, Хөтөл, Налайх, Шивээговийн усан хангамжийн системийг өргөтгөх, шинэчлэх ажлыг хийнэ.
- Даланзадгад, Мандалговь, Сайншанд хотуудын дулааны болон усан хангамжийн системийг шинэчилнэ.

Зүүн бүсэд:

- Зүүн бүсийн эрчим хүчний системийг төвийн эрчим хүчний системд холбон нэгдсэн сүлжээ үүсгэнэ.
- Хэнтийн Батширээт суманд жижиг оврын усан цахилгаан станц барих ажлыг эхлүүлнэ.
- Багануур-Өндөрхаан-Дорнодын Сүмбэр сумын чиглэлийн авто замыг барина.
- Хэнтий аймгийн Цэнхэрийн голын гүүрийг барьж ашиглалтад оруулна.
- Өндөрхаан, Баруун-Урт хотын дулааны болон усан хангамжийн системийг шинэчилнэ.

Нийслэлд:

- 10 мянгаас доошгүй айлын сууц бүхий орон сууцны хороолол барих ажлыг дэмжинэ.

- Хотын төвийн хэсгийн цахилгаан, дулаан хангамжид төхникийн шинэчлэл хийж дамжуулах, түгээх сүлжээний найдвартай ажиллагааг хангана.
- Хотын захын гэр хороолол, дагуул хотуудыг холбоожуулж, интэрнэтийн сүлжээг өргөтгэн шинэчилнэ.
- Хотын гол гудамж, авто замууд, хорооллын доторх зам талбайг нийтэд нь эрс шинэчилж өргөтгөх, хот орчмын амралт, зуслан хүртэлх замыг засч сайжруулах, гүүрүүдийн их засварыг хийх, гүүрэн гарцыг барих зэрэг арга хэмжээ авна.
- Хотын усан хангамжийн системийг шинэчлэх, захын хорооллын оршин суугчдын усны чанар, хүртээмжийг сайжруулах, хог хаягдлыг зайлцуулах болон нийтийн халуун усны үйлчилгээг өргөжүүлэх ажлыг хэрэгжүүлнэ.
- Хотын захын хорооллын ус, дулаан, цахилгаан хангамж, ариутгах татуурга, хог хаягдал зайлцуулах ажил, үйлчилгээг хувийн хэвшлийн байгууллагаар гүйцэтгүүлэх санаачлагыг өрнүүлж дэмжлэг үзүүлнэ.
- Хотын захын гэр хорооллын цахилгаан хангамжийг бүрэн шийдвэрлэнэ.

ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ БОДЛОГО

БАЙГАЛЬ ОРЧИН- ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

Байгаль орчны бодлого, арга хэмжээг бүсчилсэн хөгжлийн зорилттой уялдуулж улс орны тогтвортой хөгжлийг хангахад чиглүүлнэ.

- Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөц баялгийг нөхөн сэргээх, зохистой ашиглахад төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, нийт иргэдийг идэвхтэй оролцуулан, хамтран үр ашигтай ажиллах нөхцлийг бүрдүүлнэ.
- Бүх нийтэд экологийн боловсрол, хүмүүжил олгох, уул ус, газар дэлхийгээ хайрлан хамгаалж ирсэн үндэсний уламжлалыг цаашид өвлүүлэх ажлыг сургалт, сурталчилгааны бүхий л арга, хэлбэрийг ашиглан хийнэ.
- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх санхүүгийн тогтвортой эх үүсвэрийг бий болгоно.
- Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөтгэн байгалийн аялал жуулчлалыг дэмжин хөгжүүлнэ.
- Байгаль хамгаалал, аялал жуулчлалыг нягт уялдуулах замаар байгалийг байнгын эзэмшил тордолт, хараа хяналттай болгож, тэдгээр нь бие биөнээ дэмжин хөгжих нехцлийг бүрдүүлнэ.
- Ашигт малтмалыг байгальд халгүй аргаар ашиглахыг дэмжиж, ашигласан орд газрыг нөхөн сэргээх ажлын хяналт, урамшууллын арга хэлбэрийг үр нөлөөтэй хослуулж хэвшүүлнэ.
- Ой, түүний дагалт баялгийг зохистой ашиглах, хамгаалах, ойжуулахад гадаад, дотоодын хувь хүн, аж ахуйн нэгжийн оролцоо, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.
- Усны бодлогын шинэчлэлийг эрчимжүүлж гол, мөрний сав нутгийг хамгаалах, хэрэглээг зохистой болгох, гадаргын ус ашиглалтыг

нэмэгдүүлэх менежментийг хэрэгжүүлж гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжинэ.

- Цөөрч хорогдож буй амьтан, ургамлыг судлан хамгаалах, сэргээн нутагшуулах, тоо, толгойг өсгөх ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй төлөвлөж хэрэгжүүлнэ.
- Бүс нутгийн улс орнууд, олон улсын байгууллагын туслалцаа, дэмжлэгээр цөлжилттэй тэмцэх ажлыг эрчимжүүлж, түүнд шинжлэх ухаан, төхнөгийн орчин үеийн аргыг өргөн нэвтрүүлнэ.
- Томоохон хот, суурин газрын агаарын бохирдлыг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх цогцолбор арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж, Улаабаатар хотын агаарын бохирдлыг эрс багасгах арга хэмжээг авна.
- Хог хаягдлыг ангилан ялгах, тээвэрлэх, дахин боловсруулж ашиглах, далдлах арга, дэвшилтэт технологийг нэвтрүүлж иргэдийн амьдрах цэвэр орчинг бий болгоно.

ТАВ. ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БОДЛОГО

САЙН ЗАСАГЛАЛ-ШУДАРГА НИЙГЭМ

Хүний хөгжлийн төлөө ардчилсан, сайн засаглалыг төлөвшүүлнэ.

1. Төрийн байгуулалтын тогтолцоог боловсронгуй болгож үйл ажиллагаанд нь иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.

- Иргэдийн санал, хүсэлтэд шуурхай хандаж, төрийн үйлчилгээг сайжруулан дунд, доод шатны хүнд суртлын чирэгдлийг арилгах талаар шийдвэртэй арга хэмжээ авна.
- Төрийн үйлчилгээний байгууллагын үйл ажиллагааг ил тод, нээлттэй, хяналттай байлгах, олон нийтэд тайлагнах журмыг боловсронгуй болгоно.
- Төр болон иргэний нийгмийн байгууллагуудын хамтын ажиллагааг эрхэмлэж улс орон, үндэсний язгуур эрх ашгийн нийтлэг асуудлаар зөвшилцөлд хүрэх мөханизмыг тогтооно.
- Сумдын төрийн захиргааны албан хаагчдыг бэлтгэх ажлыг төрийн зардлаар үргэлжлүүлнэ.
- Хуулийн төсөл боловсруулахад иргэд, олон нийтийн саналыг авах, оролцоог нь өргөтгөх нөхцлийг бүрдүүлнэ. Хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжилтийг нь хангах ажлыг сайжруулна.
- “Монгол Улсын төрийн албаны шинэгээлийн дунд хугацааны стратеги”-ийг хэрэгжүүлнэ. Энэ ажлын үр өгөөжийг нэмэгдүүлэхэд олон улсын байгууллага, өндөр хөгжилтэй орнуудтай хамтран ажиллана.
- Мэргэжлийн хяналт шалгалтын чирэгдэл, давхардлыг арилгаж олон нийтэд ил тод байлгах нөхцлийг бүрдүүлнэ.
- Гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах, хойшлуулашгүй сэргээн босгох чадавхийг нэмэгдүүлэх цогц арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- Төрийн институцууд харилцан уялдаа, хяналттай ажиллах тогтолцоог

улам боловсронгуй болгож төрийн нэр хүнд, чадавхийг улам дээшлүүлнэ.

2. Эрх зүйн шинэтгэлийг гүнзгийрүүлнэ.

- Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийг хүний эрх, эрх чөлөө, түүний хууль зүйн баталгааг хангах, эдийн засаг, төрийн байгуулалтын эрх зүйн үндсийг боловсронгуй болгох, хувийн хэвшил, жижиг, дунд бизнөс, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих чиглэлээр эрчимтэй гүнзгийрүүлнэ.
- Монгол Улсын хууль тогтоомжийг системчилж, хууль тогтоомжийн давхардалт, хийдэл, зөрчлийг арилгана. Эрх зүйн эрдэм шинжилгээ, сургалт, сурталчилгааны ажлын далайц, үр нөлөөг дээшлүүлж эрх зүйн мэдээллийн үндэсний тогтолцоог бүрдүүлнэ.
- Хүн амд үзүүлэх эрх зүйн үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй болгож, төлбөрийн чадваргүй иргэдэд эрх зүйн туслалцаа үзүүлэх боломжийг нэмэгдүүлнэ.
- Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, эрх зүйн бусад баримт бичгийн хэрэгжилтэд судалгаа хийж, олон улсын эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан байгуулахын зэрэгцээ Монгол Улсын хууль тогтоомжийг олон улсын гэрээнд нийцуулнэ.
- Хуульч боловсон хүчиний боловсрол, мэдлэг, чадвар, ёс зүйд тавих шаардлагыг өндөржүүлж, тэдгээрийн давтан сургалт, сонгон шалгаруулах системийг улам боловсронгуй болгоно.
- Санхүүгийн зах зээл, оюуны өмчийн эрх зүйн хамгаалалтыг боловсронгуй болгох талаар арга хэмжээ авна.

3. Нийгмийн дэг журам, сахилга, хариуцлагыг дээшлүүлж шүүх эрх мэдэл, хууль хяналтын байгууллагын үйл ажиллагааг эрс сайжруулна.

- Хууль дээдлэх зарчмыг тууштай баримтлан “Хүний эрхийн үндэсний хөтөлбөр”-ийг дэс дараатай хэрэгжүүлж, бүх нийтийн эрх зүйн ухамсыг төлөвшүүлэхэд анхаарал тавина.
- Малын хулгай, авлига, хээл хахууль, архидан согтуурах зэрэг нийгмийн гаж үзэгдлийн эсрэг шийдвэртэй тэмцэнэ.
- Нийгмийн хэв журмыг сахиулах, хулгайн болон хүч хэрэглэсэн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох, ард иргэдийн амгалан тайван амьдрах баталгааг хангах талаар онцгой анхаарч, энэ ажилд нутгийн захиргаа, цагдаа, хил хамгаалах, тагнуулын байгууллагуудын хүчин чармайлтыг нэгтгэн ажиллана.
- Цагдаа, хил хамгаалах, хууль хяналтын байгууллагад ажиллагсдын ажиллах нөхцөлийг сайжруулж, боловсон хүчинээр бэхжүүлэх, шинэ техник, тоног төхөөрөмжөөр ханган тэдний нийгмийн хамгааллын арга хэмжээг сайжруулна.
- Шүүх, прокурорын байгууллагад ажиллагсдын хариуцлагыг өндөржүүлнэ.
- Шүүхийн захиргааны удирдлага, шүүн таслах ажиллагааны арга барилыг боловсронгуй болгоход анхаарч, шүүх эрх мэдлийн байгууллагуудыг орчин үеийн мэдлэг, чадвартай, өндөр ёс суртахуунтай боловсон хүчинээр бэхжүүлнэ.

ЗУРГАА. БАТЛАН ХАМГААЛАХ, ГАДААД БОДЛОГО

ИДЭВХТЭЙ ХАРИЛЦАА- ИТГЭЛТЭЙ ТҮНШЛЭЛ

1. Батлан хамгаалах тогтолцоог аюулгүй байдлын шинэ орчин нөхцөл, улс орны бүсчилсэн хөгжлийн бодлогод нийцүүлэн хөгжүүлж, зэвсэгт хүчнийг цомхон, чадварлаг, мэргэжлийн чиг баримжаатай болгох арга хэмжээг хэрэгжүүлнэ. Зэвсэгт хүчнийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд бэлтгэн оролцуулах явдлыг батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааны нэг чухал зорилт гэж үзнэ.

- Улс орны батлан хамгаалах тогтолцоо, цэргийн байгуулалтыг төгөлдөржүүлж орон нутгийн батлан хамгаалалтын эрх зүй, зохион байгуулалтын үндсийг бүрдүүлэн ерөнхий зориулалтын цэргийн үндсэн нэгжүүдийн зориулалт, бүтэц, байршил, хангалтыг эдийн засгийн бүсүүд, нутаг орны онцлогт нийцүүлэх арга хэмжээ авна.
- Цэрэг, цагдаагийн албан хаагчид НҮБ-ын болон олон улсын энхийг сахиулах бусад ажиллагаанд оролцдог болох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно.
- Олон улсын төрроризм, террорист халдлагын аюулаас урьдчилан сэргийлэх талаар төрийн байгууллагуудын харилцан ажиллагааг зохицуулах эрх зүйн үндсийг бүрдүүлнэ.
- Цэргийн насны залуучуудын эх оронч хүмүүжил, эрүүл мэнд, боловсролыг сайжруулах асуудлыг төрийн бүх шатны байгууллага, албан тушаалтны анхаарлын төвд байлгана.
- Цэргийн хөдөлмөрийн нийгмийн үнэлээмжийг дээшлүүлэх, Зэвсэгт хүчний нийтийн хүч чармайлт шаардсан бүтээн байгуулалтад оролцуулахыг төрийн бодлогоор дэмжинэ.
- Цэргийн шинжлэх ухаан, төхнолийг хөгжүүлэх бодлогыг баримтална. Зэвсэглэл, техникийг шинэчлэн сайжруулах арга хэмжээг шат дараатай авна.
- Багш, эмч зэрэг мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай суманд очиж ажилласан цэргийн насны залуучуудыг цэргийн дүйцүүлэх алба хаасанд тооцох эрх зүйн үндсийг бүрдүүлнэ.

2. Монгол Улсын гадаад бодлогын залгамж чанар, нэгдмэл байдлыг хадгалан үндэсний язгуур эрх ашгийг эрхэмлэн Монгол Улсын аюулгүй байдал, тогтвортой хөгжилд таатай гадаад орчин бүрдүүлэхэд чиглэсэн олон тулгуурт, нээлттэй, бие даасан, идэвхтэй гадаад бодлого явуулна.

- Хөрш орнуудтай түншлэлийн харилцаа, бүх талын хамтын ажиллагаагаа бэхжүүлж уламжлал, итгэлцэлд тулгуурласан, харилцан ашигтай байх, тэнцвэртэй харилцах үндсэн дээр сайн хөршийн хамтын ажиллагаагаа өргөтгөн хөгжүүлэхийг зорино.

- Хоёр талын харилцааг худалдаа, эдийн засаг, бизнөс, хөрөнгө оруулалтын агуулгаар баяжуулж, тэдгээртэй харилцах дунд хугацааны хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
- Дамжин өнгөрөх тээврийн асуудлаар Монгол-Орос-Хятадын гурван талын хэлэлцээрийг байгуулж хэрэгжүүлнэ. Дэлхийн худалдааны байгууллагын хүрээнд худалдааны нөхцлийг хөнгөвчлөх, үнэ, тарифыг бууруулах чиглэлээр ажиллана.
- Өрнө, дорнын өндөр хөгжилтэй орнуудтай харилцаа, хамтын ажиллагаагаа бэхжүүлж тэдний бодит сонирхлыг Монголд бий болгон зохистой түвшинд хүргэх бодлого баримтална. Эдгээр орнуудтай чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах зорилт тавьж ажиллана.
- Монгол Улс, АНУ-ын харилцаа, нягт түншлэлийг хөгжүүлэн бэхжүүлнэ. “Мянганы сорилтын хөтөлбөр”-ийн дагуу тусlamж авах чиглэлээр ажиллана. АНУ-тай Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулахыг зорино.
- Иж бүрэн түншлэлийн зорилтыг хамтын ажиллагааны суурь болгон Япон улстай улс төр, эдийн засаг, соёлын болон бусад салбарт харилцааг цаашид өсгөхийг эрхэмлэнэ. Худалдаа, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх тухай хэлэлцээр байгуулах чиглэлээр ажиллана.
- Монгол, Европын Холбооны харилцааны түвшинг ахиулах, Ази, Латин Америкийн хөтөлбөрийн хүрээнд хамтын ажиллагаагаа хөгжүүлж, Монгол Улсад үзүүлж буй тусlamжийн хэмжээг бууруулахгүй байх зорилттой ажиллана. НАТО-гийн “Энхийн төлөө түншлэлийн хөтөлбөр”-т орохыг зорино.
- Ази, Номхон далайн бүсэд идэвхтэй үйл ажиллагаа явуулж, хоёр талын болон олон талт хамтын ажиллагааг урагшуулах, бүсийн хэмжээний улс төрийн яриа, хэлэлцээний бүтэц, эдийн засгийн интеграцийн үйл явцад хамрагдах чиг баримтална.
- АПЕК-ийн ажлын хэсгүүдэд манай улсын оролцоог идэвхжүүлж, тус байгууллагад гишүүнээр элсэх зорилттой ажиллана.
- Зүүн Хойд Азид энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэх, тогтвортой байдлыг хангахад хувь нэмэр оруулахыг зорино. Зүүн Хойд Азид улс төрийн яриа, хэлэлцээний механизм бий болгох хүч чармайлтаа үргэлжлүүлнэ.
- Түмэн голын төслийн хэрэгжилтийг түргэтгэх чиглэлээр бусад оронтай хамтран ажиллах, эрчим хүч, тээвэр, бусад салбарт бүсийн хамтын ажиллагааг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллана.
- Ази, Европын уулзалт, Азийн хамтын ажиллагааны яриа, хэлэлцээ зэрэг олон талт үйл явцад хамрагдах чиг баримтлана.
- Монгол Улсын аюулгүй байдлыг баталгаажуулах чиглэлээр НҮБ, түүний төрөлжсөн болон системийн байгууллагууд, Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн зэрэг олон улсын нөлөө бүхий байгууллагуудтай тогтоосон харилцаа, хамтын ажиллагааг бататган хөгжүүлэхийг зорино.
- Ардчиллыг шинээр болон сэргээн тогтоосон орнуудын 5 дугаар бага хурлаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх талаар тодорхой үйл ажиллагаа явуулж, тус хөдөлгөөнд оролцогч орнуудтай идэвхтэй хамтран ажиллана.
- НҮБ болон олон улсын бусад байгууллага, мөханизм, үйл явцын хүрээнд жижиг, далайд гарцгүй, эмзэг эдийн засагтай орны эрх ашигт нийцсэн бодлого, үйл ажиллагааг эрчимжүүлнэ.

- Олон улсын терроризм, зохион байгуулалттай гэмт хэрэг, мансууруулах бодисын наймаа, байгаль орчны бохирдол зэрэг уламжлалт бус аюул заналтай тэмцэх талаар дэлхийн хамтын нийгэмлэгээс тавьж буй хүчин чармайлтад туштай хувь нэмэр оруулахыг эрмэлзэж ажиллана.
- Мянганы хөгжлийн зорилтуудыг үндэсний хэмжээнд үр дүнтэй хэрэгжүүлнэ.
- Дорнод Европ болон уламжлалт харилцаатай бусад оронтой шинэ нөхцөлд зохицуулан сэргээн хөгжүүлж буй харилцаанд гарсан ахицыг бататгаж хамтын ажиллагаагаа бэхжүүлэх чиглэлээр ажиллана.

Монгол Ардын Хувьсгалт Нам энэхүү хөтөлбөрийг **ТАНЫ ТӨЛӨӨ ТАНТАЙ ХАМТ** хэрэгжүүлснээр Монгол хүн Та эрүүл, аюулгүй орчинд амьдарч, чанартай боловсрол эзэмшиж, хүртээмжтэй үйлчилгээ авч, эрх чөлөөтэй, ая тухтай, чинээлэг, бүтээлч, ирээдүйдээ итгэлтэй ажиллаж амьдрах бүх талын бололцоо бүрдэнэ.

МОНГОЛ АРДЫН ХУВЬСГАЛТ НАМ